

ТАНИЛЦУУЛГА

*“Маягтын загвар, аргачлал батлах тухай”
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Сангийн сайдын хамтарсан тушаалын
төсөл боловсруулсан тухай*

2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр

1. Өнөөгийн байдал:

Нийгмийн даатгалын тухай болон нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тухай хуулиуд 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж одоог хүртэл мөрдөгдөж байна. Өнөөдрийн байдлаар тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний болон ажилгүйдлийн даатгалын сан, нийт 4 сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд (хуучин нэрээр)-ын 2006 оны 18/03 тоот хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын санд хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг нөхөх заавар”-ыг мөрдөн анх ажиллаж байсан. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх журмыг Үндэсний Статистикийн хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/73 дугаар тушаалаар зөвшөөрсний дагуу Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Маягт, журам батлах тухай” 246, А/245 дугаар тушаалаар батлан, мөрдөж байна. Дээрх хамтарсан тушаалаар нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн 34 маягт /З-НД, Б-НД/, түүнийг хөтлөх журмыг баталсан.

2. Зорилго:

Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, түүнийг хөтлөх аргачлалыг нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд нийцүүлэн баталснаар нийгмийн даатгалын мэдээллийн санг бүрдүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулах, ажил олгогч, даатгуулагч, хүнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх, нийгмийн даатгалын сангийн үр дүнгийн талаарх нэгдсэн мэдээллийг гаргах ач холбогдолтой.

3. Үндэслэл:

Уг маягт, аргачлалыг боловсруулахдаа Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг үндэслэл болгосон болно.

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбоотой нийгмийн даатгалын үйлчилгээний нэр, төрөл, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох нөхцөл болзол, даатгуулагчийн төрөл, нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо өөрчлөгдсөн зэрэг хэрэгцээ шаардлагын тус тус үндэслэн нийгмийн даатгалын

сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны 18 маягтын загвар болон түүнийг хөтлөх аргачлалын төслийг боловсруулав.

4.Хэрэгцээ:

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсаны дагуу шинээр мөрдөгдөх зохицуулалт, хуулийн нэр томъёоны өөрчлөлт болон тусгайлан эрх олгосон хуулийн заалтууд өөрчлөгдсөн зэрэг хэрэгцээ шаардлагыг тус тус үндэслэн нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны 18 маягтын загвар болон түүнийг хөтлөх аргачлалын төслийг боловсруулав.

5.Маягт, аргачлалын төслийг боловсруулсан тухай:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 03/2861 тоот албан бичгээр санал авахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/2238 тоот албан бичгээр санал ирүүлж, тушаалын төсөлд холбогдох саналын тусган, 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3286 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах, хуваарь батлах тухай” 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/176 дугаар тушаалаар байгуулагдсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх журам, заавар, дүрэм, аргачлал боловсруулж батлуулах ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр, 11 дүгээр сарын 15-ны өдөр, 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тус тус хуралдсан.


Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны www.mlsp.gov.mn цахим хаягт “Маягтын загвар, аргачлал батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байршуулж санал авсан. Энэ хугацаанд ямар нэг санал ирээгүй болно. (Хуулбарыг хавсаргав)

Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягт түүнийг хөтлөх аргачлалыг Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлахыг зөвшөөрсөн зэрэг тус тус болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас
www.mlsp.gov.mn

Нүүр Яамны тухай Бодлого, чиглэл Мэдээ, мэдээлэл Хууль эрх зүй Ил тод Шилэн данс

Төрийн үйлчилгээ 11-11 төв 1212.MN



Самал авч байна 2023-11-10

"Магтын загвар, аргачлал батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төсвийг Самал авч байна.

Үндэсний Статистикийн хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/73 дугаар тушаалаар эвсөөрсний дагуу Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Магт, журам батлах тухай" 246, А/246 дугаар тушаалаар анхан шатны бүртгэлийн магт, түүнийг хөтлөх журмыг баталж, мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, нэвтрэмжээ шалтгаалсан өмчийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дэх хэсэгт "Нийгмийн даатгалын сангийн нэгтгэн бодол бүртгэлийн анхан шатны магтын загвар, түүнийг хөтлөх аргачлалыг" хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлана" гэж заасан.

- Самал авч байна
- Тайлан мэдээ
- Хууль эрх зүй
- Ковид-19
- Хөдөлмөр эрхлэлт
- Мэргэжлийн боловсрол, сургалт
- Хөдөлмөрийн харилцаа
- Нийгмийн даатгал
- Хүн амын хөгжил
- Нийгмийн халамж
- Мэргэжлийн боловсрол, сургалт
- Ил тод

Нүүр Яамны тухай Бодлого, чиглэл Мэдээ, мэдээлэл Хууль эрх зүй Ил тод Шилэн данс

Төрийн үйлчилгээ 11-11 төв 1212.MN

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дэх хэсэгт "Даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, шимтгэл төлөх сарын цахил хэлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, шимтгэл төлөх хугацаа, талуудын ари, үүрэг, хариуцлага, гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах, цуцлах, дуусгавар болж эзрэг хариуцаж зохицуулсан журам болон сайн дүрээр даатгуулах гэрээний загварыг өндөрлөх, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дэх хэсэгт "Эмнэлгийн хуудасны магтын загвар, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж тус тус заасны дагуу анхан шатны бүртгэлийн магнтаас хассан.

Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд шинээр мөрдөгдөх зохицуулалт болон хуулийн нэр томъёоны өөрчлөлт, тусгайлан эрх олгосон хуулийн заалтууд өөрчлөгдсөн зэрэг хэрэгцээ шаардлагыг тус тус үндэслэн нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн үндсэн 25 магтын загвар болон түүнийг хөтлөх аргачлалын төслийг боловсруулав.

Хавсралт файл

№	Гарчиг	Татах
1	"Магтын загвар, аргачлал батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг тэмдэглүүлж	Татах
2	"Магтын загвар, аргачлал батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төсөл	Татах

☎ 203 [Хуваалцах](#) [f](#) [t](#)

- Хүний нөөц
- Зар, мэдээ
- Статистик мэдээлэл
- Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл
- Төсөл, хөтөлбөр
- Бодлого, төлөвлөлт
- Тайлан
- Авлигын эсрэг үйл ажиллагаа
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- Салбарын хяналт

Ажлын хэсгийн хуралдаан



Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөлийн хуралдаан 2024.01.05



---oOo---